



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 01466

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 4,000,000.0 /дөрвөн сая/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ~~



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны . . . дүгээр сарын . . . өдрийн . . . дугаар тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтанд авсан огноо	Танар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Эх үүсвэр	
								Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Гэрэлтүүлэг	8 м лед	100вт	2019	сайн	ш	4	1,000,000	4,000,000	"Цалгайн бууц" СӨХ /5-р хороо, 10-р хороолол 81-р байрны зүүн талд/	Хандив
Нийтийн эзэмшлийн дүн								4,000,000	4,000,000		
Нийт бүртгэх дүн								4,000,000	4,000,000		